

**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо: 2022 оны 3 сарын 23-ны өдөр

Цаг: 10:00

Хэлбэр: Цахим/Zoom/

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ тогтоолыг танилцуулах;
4. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай;
5. Нэмэлт хувьцаа гаргах талаар хэлэлцэн батлах;
6. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;
7. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай хэлэлцэн батлах;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсөв батлах;
9. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах;
10. Бусад

Тооллогын комиссын дарга Ж.Ганхүлэг хурлын ирц танилцууллаа.

Хурлын ирц: 56.4%

Хурлын дарга Ч.Чинзориг: За хурал нээснийг мэдэгдэж байна.

Хурлын ирцийг харахад өмнөх Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцээс 6 орчим хувиар өндөр байна. Энэ өндөр хувьтай хурал эхэлж байгаатай холбогдуулаад би нэг товчхон танилцуулгыг хурлын дэгийг танилцуулахаас өмнө өгье гэж бодож байна.

Манай банк бус санхүүгийн байгууллага хувьцаат компани болсноор сүүлийн 3 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн тоо, зах зээл дээрх хувьцааны арилжааны тоо, арилжаалагдаж байгаа хувьцааны үнийн дүн өсөж байгаа. Хувьцааны үнэ өнгөрсөн оныхоос 10 гаран хувиар өндөр байгаа юм.

Өнөөдрийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №2 “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг танилцуулах;
4. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох;
5. Нэмэлт хувьцаа гаргах талаар хэлэлцэн батлах;
6. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;
7. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай хэлэлцэн батлах;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсөв батлах

9. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах;
10. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт
11. Саналын хуудсаар санал авах
12. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх
13. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах

Та бүхэнд хурлын дэгийг танилцууллаа.

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал Золжаргал танилцуулна.

Хэлэлцэх асуудал 1.

Гүйцэтгэх захирал Б.Золжаргал: За сайн байцгаана уу. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулъя. Компани 2021 онд 2.6 тэрбум төгрөгийн дүрмийн сантай, 6.3 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байна. Зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, Итгэлцлийн үйлчилгээ гэсэн 4 үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Компани 2021 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх болон Итгэлцлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл нэмж авах тухай шийдвэр тогтоолууд гарсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хувьд ээлжит болон ээлжит бусаар 9 удаа хуралдсан бөгөөд уг хурлуудаар компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах, Санхүүгийн зохицуулах хорооны болон хууль дүрмүүдийн шинэчлэлтэй холбогдуулан компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журмуудыг шинэчлэн батлах, Завхан аймагт үйл ажиллагаагаа явуулахаар зөвшөөрөл авч байсан салбар нэгжийг татан буулгах, 2020 онд ногдол ашиг хуваарилах тухай, 3 жил тутамд хийгддэг хөрөнгийн үнэлгээний байгууллагыг сонгох зэрэг хэд хэдэн гол асуудлуудыг шийдвэрлэсэн. 2021 оны онцлох үйл явдлуудаас дурдвал компани хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргаснаар 2.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Уг хөрөнгө оруулалтыг зээлийн эргэлтийн хөрөнгөд зарцуулсан. Мөн СЗХ-ны 441 тоот тогтоолын дагуу дүрмийн сангаа 2.6 тэрбум болгосон. 2021 оны хурлаар шийдвэрлэсэн Итгэлцлийн үйл ажиллагааны чиглэлийг нэмж авсан бөгөөд 1 тэрбум төгрөг харилцагчдаас татан төвлөрүүлээд эргэлтийн хөрөнгөд зарцуулсан байгаа. Дараагийн гол үйл явдал бол Хөрөнгийн биржийн 3-р ангилалд байсан үзүүлэлтээс компанийн үйл ажиллагаа сайжирсан тул 2-р ангилалд шилжсэн.

Хэлэлцэх асуудал 2.

Санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитыг СЗХ-нд бүртгэлтэй “Шинэ их тэрбум” Аудитын байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Санхүүгийн тайлангаас гол үзүүлэлтүүдийг дурдвал Компанийн нийт хөрөнгө 183 хувиар, өөрийн хөрөнгө 138 хувиар өссөн байгаа. Энэ нь хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргасантай холбоотой. Компани 2021 онд нийт 8 тэрбум төгрөгийн зээл олголт хийж, хүүгийн орлого 77 хувиар, цэвэр ашиг 3.5 дахин буюу 972.0 сая төгрөгийн ашигтай ажилласан үзүүлэлттэй байна. Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ салбарын гол үзүүлэлттэй компанийн үзүүлэлтүүдийг харьцуулбал бүх үзүүлэлтүүд маань сайжирсан байна. Үүнээс нэг гол үзүүлэлт болох чанаргүй зээлийн хувьд Банк бус санхүүгийн салбарын хувьд 7.0 хувь гэсэн өндөр үзүүлэлттэй байгаа бол компани 2021 онд 1.3 хувийн чанаргүй зээлтэй байна. Энэ нь нийт дүнгээрээ 4 зээлдэгчийн 88.0 сая төгрөгийн зээл ангилагдсан буюу муу ангилалд шилжээд шүүхийн процесс дээр явж байна. 2022 оны бизнес төлөвлөгөөнд дараах 2 үзүүлэлтийг харгалзан үзсэн. Нэгт компани нэмэлт хувьцаа гаргаж, хөрөнгө оруулалт татах, хоёрт өнөөгийн эдийн засаг, инфляц болон бусад санхүүгийн үзүүлэлтийг харгалзан үзэж, компани 2022 онд 3-5 хувийн өсөлттэй байна гэж таамаглаж байгаа. Нийт эздийн өмч хөрөнгө оруулалт татсанаар 12.2 тэрбум болно гэж үзэж байна. Мөн хүүгийн орлого 3,6 тэрбум, татварын дараах цэвэр ашиг 2.7 тэрбум байхаар төсөөлж байна.

За дараагийн асуудал болох Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг Б.Энх-Амгалан танилцуулна.

Ч.Чинзориг: За Золоо захиралдаа баярлалаа.

Б.Энх-Амгалан: За та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Тандэм Инвэст ББСБ”ХК-ийн Аудитын хорооны дүгнэлтийг та бүхэндээ танилцуулъя. Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм, хууль тогтоомж, хувь нийлүүлэгчээс олгогдсон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж байгаа эсэх, хөндлөнгийн аудитын байгууллагыг хэрхэн сонгон ажилласан талаар хяналт тавин ажилласан болно. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанаас дурдвал Тандэм Инвэст ББСБ ХК нь жилийн эцсийн санхүүгийн тайланд СЗХ-нд бүртгэлтэй Шинэ их тэрбум аудитын компаниар хөндлөнгийн аудит хийлгүүлсэн байна. Компани 2021 онд 1.1 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх онтой харьцуулбал 495.0 сая төгрөгөөр илүү буюу 77 хувиар өссөн дүнтэй гарсан байна. Ковид 19 цар тахлаас улбатайгаар 2020 онд цэвэр ашиг 26.6 хувиар буурч байсан бол 2021 оноос энэ хязгаарлалтыг сулруулж эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой түвшинд чөлөөлсөн нь иргэд аж ахуй нэгжийн хувьд харьцангуй чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн. Үүнтэй холбоотойгоор эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж байгаа нь компанийн хувьд 2021 хувьд хуримтлагдсан ашиг өмнөх онтойгоо харьцуулахад нэмэгдэх боломж үүссэн гэж харж байна. Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл цалингийн зардал 203.0 сая төгрөг аудит, мэргэжлийн үйлчилгээний зардал 89.5 сая төгрөг, түрээс 17.6 сая төгрөг, НДШ, ЭМД-тай холбоотой зардал 19.9 сая төгрөг, маркетинг сурталчилгааны зардал 4.4 сая төгрөг, зохицуулалтын үйлчилгээний хураамж 12.7 сая төгрөг, зээл барагдуулахтай холбоотой зардал 800 мянган төгрөг байна. Орлогын гүйлгээний хувьд тайлант хугацаанд бусдаас авсан өр төлбөргүй, богино хугацааны өр төлбөр 1.1 тэрбум төгрөг байгаагаас 1.0 тэрбум төгрөг нь Итгэлцлийн өглөг байна. Татварын өр төлбөр 3.5 сая төгрөг байна. За эздийн өмч ба өр төлбөр, богино хугацаат өр төлбөрийн дүн 16.1 хувийг эзэлж байгаа, урт хугацааны өр төлбөргүй. Эздийн өмч, өр төлбөрийн нийт дүнд эзлэх хувь нь 83.9 хувьтай байна. 2021 оны эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн хэмжээ 43.7 сая төгрөг болсон энэ нь өмнөх онтой харьцуулбал 95 хувиар өссөн дүнтэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналын хувьд компани 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагаанд анхан шатны баримт, бусад баримт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж ажилласан байна. Хараат бус аудитын дүгнэлтээс ББСБ-ын санхүүгийн тайлагналыг олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэлээ. За баярлалаа.

Хэлэлцэх асуудал 3.

Ч.Чинзориг: Аудитын хорооны дарга Энх-Амгаланд баярлалаа. Дараагийн танилцуулах асуудал бол компани 2022 онд ногдол ашиг хуваарилах тухай юм. 2021 онд манай компани 972.0 сая төгрөгийн ашигтай ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 сарын 11 өдрийн хурлаас нэгж хувьцаанд 85 мөнгө буюу нийт 961.0 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны ногдол тараалтын талаар мэдээлэхэд компани 2021 онд 845 хувьцаа эзэмшигчдэд 119.5 сая төгрөгийн ногдол ашиг тараасан бөгөөд холбогдох тайлан мэдээг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн.

Хэлэлцэх асуудал 4.

Ч.Чинзориг: Дараагийн хэлэлцэх асуудал бол ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал байна. 2019 онд Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүдийг 3 жилийн хугацаатайгаар сонгосон. Энэ онд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болж байгаа. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороонд ирсэн анкетын дагуу ердийн гишүүнд Ч.Чинзориг, Л.Очирмаа, Ч.Бадмаараг, Ц.Билэг-Өрнөх, Ч.Тэмүдэр, Б.Золжаргал. Хараат бус гишүүнд Л.Даваазориг, Ч.Лодойравсал, Б.Энх-Амгалан нарыг томилохоор та бүхэнд танилцуулгыг хүргүүлж байна. Слайд дээрээс та бүхэн харах учраас товчхон танилцуулаад явъя. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгож байгаа болно.

Хэлэлцэх асуудал 5.

Ч.Чинзориг: Хэлэлцэх 5 дугаар асуудал хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа тухай. Өнгөрсөн жил манай компани хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж 11.9 хувийн хувьцааг 19 төгрөгөөр худалдаж 2.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Уг хувьцаа эзэмшигчид бид энэ онд дахин хаалттай хүрээнд хувьцаа гаргахаар санал болгож байгаа. Санал болгож байгаа хувьцаа нь компанийн хувьцааны 25 хувь болох 377,029,177 ширхэг энгийн хувьцааг сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханшнаас 50 мөнгөөр илүү дүнгээр буюу 19.50 төгрөгөөр санал болгож байгаа. Хувьцааны үнийг яагаад өндөр дүнтэй санал болгож байна вэ гэвэл манай компанийн үйл ажиллагаа, үр ашиг өгөөж тогтвортой өсөж байгаа учраас юм. Татан төвлөрүүлэх нийт дүн бол 7,352,068,951 төгрөг байна. Бид стратегийн хөрөнгө оруулагчид эзэмшүүлэх зорилгоор хаалттай хүрээнд санал болгож байгаа учир Компанийн тухай хуулийн 38.8-д зааснаар Тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх санал оруулж байгаа. Та бүхэн энэ асуудал дээр саналаа өгөөрэй.

За хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах асуудлыг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал 6.

Ч.Чинзориг: Дараагийн асуудал бол дүрмийн сан нэмэгдүүлэх асуудал байна. Компанийн дүрмийн санд нэмж татан төвлөрүүлж байгаа хөрөнгөтэй холбоотойгоор өөрчлөлт орно. Дүрмийн сан 2,601,501,321 төгрөгөөс 3,468,68,428 төгрөг болж, хувьцааны тоо ширхэг 1,131,087,531 ширхгээс 1,508,116,708 ширхэг болж, эздийн өмч 12,262,548,489 төгрөг болж өөрчлөгдөх байна.

Хэлэлцэх асуудал 7.

Ч.Чинзориг: Дараагийн хэлэлцэх асуудал нь үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нэмж авах тухай. Үйл ажиллагаандаа хэрхэн өөрчлөлт оруулах, нэмж авах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн талаар гүйцэтгэх захирал Золжаргал та бүхэнд танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Золжаргал: Компанийн бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны хүрээг тэлэх үүднээс жил бүр үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авч байхаар тусгасан байгаа. 2021 онд итгэлцлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нэмж авсан. 2022 онд 7.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж байгаатай холбогдуулан зайлшгүй тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байна. Энэ онд нийт 6.3 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байгаа. Зээлийн багцын 66 хувийг автомашин, хөдлөх хөрөнгөд зориулсан зээл эзэлж байна. Нийт активын эрсдэлийг бууруулах үүднээс 4 төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авахаар хэлэлцэх асуудалд оруулсан. Нэгт богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хоёрт цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гуравт төлбөрийн баталгаа, дөрөвт факторингийн үйл

ажиллагааны зөвшөөрлийг авахаар төлөвлөсөн байна. Шинээр нэмж авах тусгай зөвшөөрлийн талаар та бүхэнд слайд дээрээс товчхон танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 8.

Гүйцэтгэх захирал Б.Золжаргал: Дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн 2022 оны төсөв байгаа. Төсөвтэй холбоотой асуудлыг ТУЗ-ийн дарга танилцуулна.

Ч.Чинзориг: 2021 оны ТУЗ-ийн төсөвлөсөн зардлаас албан томилолтын зардлыг зарцуулаагүй байгаа. Энэ онд бид ТУЗ-ийн ээлжит бус хурал, томилолтын зардлыг өсгөсөн байгаа. Бусад зардалд өөрчлөлт ороогүй байна. Бид компаниа үр ашигтай ажиллуулах талаас нь ач холбогдол өгч ажилладаг учраас гарч байгаа зардлуудыг танаж, аль болох зардал бага гаргах талаас нь шийдвэр гарган ажиллаж байна. Хурлын танилцуулга дээр харагдаж байгаагаар 2022 оны ТУЗ-ийн зардлыг 76,320,000 төгрөг байхаар төсөвлөсөн болно.

Хэлэлцэх асуудал 9.

Ч.Чинзориг: Сүүлийн хэлэлцэх асуудал болох компанийн дүрэмд орох өөрчлөлтийн талаар гүйцэтгэх захирал Золжаргал танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Золжаргал: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудын дагуу компанийн дүрэмд 6 заалт өөрчлөлт орох байгаа. Үүнээс 4 заалт нь үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авахтай холбогдуулаад компанийн дүрмийн 3.1.5-с 3.1.8 хүртэл шинээр нэмэгдэж байна. Хоёрт нэмэлт хувьцаа гаргахтай холбогдуулаад компанийн дүрмийн 6.1.1-д компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэрлэсэн үнэ 2 төгрөг 30 мөнгөөр нийт гаргасан хувьцааны тоогоор үржүүлээд дүрмийн сан нийт 3,468,668,428 төгрөг болж нэмэгдэнэ. Мөн нэмэлт хувьцаа гаргахтай холбогдуулаад компанийн дүрмийн 6.2.2-т компанийн нийт гаргасан хувьцааны тоо 1,508,116,708 болж өөрчлөгдөхөөр байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлуудын танилцуулга ингээд дуусаж байна. Одоо өмнө ярьсан асуудлуудтай холбоотой санал асуулга явуулаад, дараа нь саналын хуудсаараа саналаа авъя. За баярлалаа.

Ч.Чинзориг: За баярлалаа Золжаргал захирлаа. Санал асуулга байвал микрофоноо нээгээд асуултаа асуугаарай.

Хувьцаа эзэмшигч Мягмардорж овогтой Шигшээ: Аан за. Танайх Эко ногоон зээл гаргадаг уу. Би агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр төслийн байгууллагад ажилладаг юмаа. Цаашдаа үйл ажиллагаагаа тэлэх гэсэн хүсэл зорилготой байгаа юм. Энэ чиглэлээр эко зээл гаргах боломж байдаг уу.

Ч.Чинзориг: За би энэ асуултад хариулъя. Гүйцэтгэх захирал Золжаргал та нэмэх зүйл байвал хэлээрэй.

Бид үйл ажиллагаагаа цаашдаа тэлэх зорилготой байгаа. Ер нь тодорхой бонд, итгэлцэл өндөр хүүтэй зээл татахаасаа хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж нэмэлт хувьцаа гаргах замаар зээлийн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож байгаа болохоор цаашдаа үйл ажиллагааны чиглэлээ нэмэгдүүлэх хүсэл зорилго бий. Эко зээлийн хувьд тодорхой төслийн байгууллагуудаас яг энэ зах зээлд нь зориулаад хамтарсан байдлаар зээл бүтээгдэхүүнийг гаргах боломж бий болох байх гэж бодож байна. Цаашид компанийн үйл ажиллагаанд оруулъя гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Мягмардорж овогтой Шигшээ: За баярлалаа. Цаашдаа өргөжин тэлэх болтугай гэж ерөөж байна.

Ч.Чинзориг: За баярлалаа би цаашдаа их хичээж ажиллах болно.

Хувьцаа эзэмшигч Содномдаржаа овогтой Баярмаа: Надад нэг асуулт байна. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг би авах боломж байгаа юу?

Ч.Чинзориг: Энэ удаа хаалттай хүрээнд стратегийн хөрөнгө оруулагчид санал болгож байгаа болно. Компанийн 5 жилийн төлөвлөгөөнд 2023-2025 онд олон нийтэд нэмэлт энгийн хувьцаа гарахаар төлөвлөж, холбогдох ажлуудын судалгаа хийгдэж байгаа болно. За хувьцаа эзэмшигчдээс өөр нэмэлт асуулт байхгүй бол асуулт хариултаа өндөрлөөд санал хураалтаа явуулах уу.

Тооллогын комиссын дарга Ж.Ганхүлэг: Тооллогын комиссын дүн гарч дууслаа. Тооллогын комисст даргаар Ж.Ганхүлэг, гишүүдээр Б.Болормаа, Г.Азбилэг нар ажиллаа. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны 3-р сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дээрх 8 асуудлыг хэлэлцэж саналыг саналын хуудсаар авч баталгаажууллаа. Санал авсан 8 асуудлаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99,9 хувийн саналаар дэмжигдсэн байна. Ингээд тооллогын комиссын шийдвэрийг танилцуулъя.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2022 оны 3 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 1,130,809,531 ширхэг хувьцаанаас тус өдрийн хуралд 638,328,395 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 56,44% болж ирц бүрдсэн байна. Энэ нь хурлын ирц Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д заасан болон Компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн.

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.
3. Компанийн ТУЗ-н гишүүдийг сонгох талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.
4. Компанийн Нэмэлт хувьцаа гаргах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан. Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.
5. Компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.
6. Компани үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.
7. 2022 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56,4% саналаар зөвшөөрч баталсан.

8. Компанийн дүрмийн өөрчлөлтүүдийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 56.4% саналаар зөвшөөрч баталсан.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: *Б.Бадамцэцэг* /Б.Бадамцэцэг/

Хурлын дарга: *Ч.Чинзориг* /Ч.Чинзориг/

